



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 06 сарын 22 өдөр

Дугаар 320

Улаанбаатар хот

Төрийн өмчид эд хөрөнгө хүлээн авч бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйл, "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дэх заалт, Дорнод аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 10 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Дорнод аймгийн өмчөөс шилжүүлсэн, 27,000,000.00 (хорин долоон сая) төгрөгийн балансын үнэ бүхий автомашиныг төрийн өмчид хүлээн авч хавсралтад заасны дагуу Дорнод аймгийн Онцгой байдлын газрын үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Дорнод аймгийн Онцгой байдлын газрын дарга, хурандаа Г.Нармандахад дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Комисс томилон хөрөнгө хүлээн авч, бүртгэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Автомашиныг улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлж, хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2023 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.


ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2023 оны 06 дугаар сарын 22 өдрийн
220 дугаар тогтоолын хавсралт



Дорнод аймгийн өмчөөс төрийн өмчид хүлээн авч Дорнод аймгийн Онцгой байдлын газарт эзэмшүүлж, бүртгэх хөрөнгийн жагсаалт

д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтанд орсон он	Тоо хэмжээ	Балансын үнэ /төгрөг/	Хуримтлагдсан элдэгдэл /төгрөг/	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	Уаз фургон, улсын дугаар 41-32 ДОР	2013	1	27,000,000.00		27,000,000.00
	Нийт дүн			27,000,000.00 (хорин долоон сая)		27,000,000.00 (хорин долоон сая)